

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	12
2.1 Төв аймгийн Баянчандмань сумын байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга.....	12
2.2. Төслийн талбайн өнөөгийн газрын гадарга, төлөв байдал	13
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	17
3.1. Нөлөөллийн хэлбэр үргэлжлэх хугацаа.....	17
4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	19
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	20
6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	24
7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	25
8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	26
Төслийн үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдлыг ангилан ялгаж дахин ашиглах боломжтой хог хаягдлыг хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгт хүлээлгэн өгч байнга хамтран ажиллан хог хаяглын хэмжээг бага байлгахад анхааран ажиллах.	26
9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	27
10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	28
11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	29

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Газрын гэрчилгээний 000018766 дугаартай 7.32 га газрын булангийн цэгүүд ...	3
Хүснэгт 2. Баянчандмань сумын газрын сангийн ангилал.....	12
Хүснэгт 3. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим ба эх үүсвэр	17
Хүснэгт 4. 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал..	19
Хүснэгт 5. Төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ.....	20
Хүснэгт 6. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	24
Хүснэгт 7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	25
Хүснэгт 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	26
Хүснэгт 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	27
Хүснэгт 10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	28
Хүснэгт 11. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	29

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн ерөнхий байршлын зураг	5
Зураг 2. Төслийн талбайн районы агаар, сансрын зураг	6
Зураг 3. “ЭМЖЖ сувилал” нь А болон Б корпус 2 давхар байгууламж,	9
Зураг 4. Төслийн талбайн барилга байгууламжийн зураг	9
Зураг 5. Сувиллын амрагчийн өрөө нь энгийн болон люкс ангиллын бөгөөд	10
Зураг 6. Сувиллын хөдөлгөөн заслын болон бялдаржуулах танхим, спорт зал, гадаа талбай нь орчин цагийн хэрэглэгчийн хүсэл шаардлагад бүрэн нийцнэ	11
Зураг 7. Автомашины зогсоол болон явган хүний зам гэрэлтүүлэг, сүүдрэвч.....	11
Зураг 8. Төслийн талбайн фото зураг	14
Зураг 9. Төслийн талбайн районы д.т.д үнэмлэхүй өндөр (метр).....	15
Зураг 10. Төслийн талбайн районы газрын гадаргын налуу (градус)	16

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн нэр : “Улсын үйлчилгээтэй ЭМЖЖ сувилал”-ын төсөл

Төслийн зорилго:

Улсын хэмжээнд

- Сонсголын бууралттай, таг дүлий хөгжлийн бэрхшээлтэй бүх насны иргэд болон чих шуугих өвчтэй иргэд;
- Тэнцвэр алдагдлын эмгэгтэй бүх насны иргэд;
- Амьсгалын замын өвчлөлтэй бүх насны иргэдийг байгалийн өндөр хүчилтөрөгчийн агууламж бүхий цэвэр агаарын эмчилгээ болон уламжлалт анагаах ухаан, бүх төрлийн физик эмчилгээ, хөдөлгөөн засал эмчилгээ зэргээр байгалийн сайхан, ногоон бүсэд эмчлэн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлж, экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүнээр хангаж, үйлчлүүлэгчдийг эрүүлжүүлж, эрүүл мэндийг бэхжүүлэхэд чиглэнэ.

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр:

- “ЭМЖЖ” ХХК
 - Хувийн хэргийн дугаар:9011008110
 - Регистрийн дугаар: 2046458

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг, утас:

- Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Автозамчдын гудамж, Парисын гудамж 43,
- Утас: 976-99295544

Төслийн байршил:

Төв аймгийн Баянчандмань сумын нутаг, Дарцагт уулын энгэрт эзэмшил газар нь нийт 7.32 га талбайг эзлэн Улаанбаатар хотоос 51 километрт байрлана.


- Талбайн хэмжээ: 7.32 га
- Талбайн байр зүйн зургийн нэрэлбэр: М-48-12

Газарзүйн солбицол


Хүснэгт 1. Газрын гэрчилгээний 000018766 дугаартай 7.32 га газрын булангийн цэгүүд

№	Уртраг			Өргөрөг		
	градус	минут	секунд	градус	минут	секунд
1	106	23	49.71	48	7	9.77
2	106	23	46.37	48	7	10.33
3	106	23	35.18	48	7	15.19
4	106	23	35.89	48	7	15.6
5	106	23	33.99	48	7	17.07
6	106	23	33.63	48	7	17.29
7	106	23	32.84	48	7	17.92
8	106	23	32.11	48	7	18.07
9	106	23	31.73	48	7	18.84
10	106	23	31.34	48	7	19.6

№	Уртраг			Өргөрөг		
	градус	минут	секунд	градус	минут	секунд
11	106	23	30.06	48	7	19.31
12	106	23	28.79	48	7	19.03
13	106	23	29.51	48	7	21.34
14	106	23	29.82	48	7	22.25
15	106	23	52.25	48	7	15.05
16	106	23	52.23	48	7	15.01
17	106	23	51.56	48	7	13.6



Зураг 1. Төслийн талбайн ерөнхий байршилын зураг



Зураг 2. Төслийн талбайн районы агаар, сансрын зураг

Төслийн товч тодорхойлолт, хүчин чадал:

“ЭМЖЖ сувилал” нь анх 2006 онд байгуулагдан одоог хүртэл эргэн тойрон модоор хүрээлэгдсэн Дарцагт уулын энгэрт хүчил төрөгч баялаг ялгарсан эрүүл цэвэр агаарт амрагч, сувилуулагчдад гэрлэн эмчилгээ, төрөл бүрийн цахилгаан болон физик эмчилгээ, Электрофорез эмчилгээ, рашаан засал \Оргил рашаан\, шавар засал, элсэн шарлага, толгой, хүзүү, сээр, нурууны бариа, бумба, парфин эмчилгээ, зүү төөнүүр эмчилгээ, хөдөлгөөний дасгал, агаар буюу хүчилтөрөгчийн эмчилгээ, давсан замын эмчилгээ, цагаан идээ, зуны улиралд гүүний саам зэрэг эмчилгээ сувилгааг хийдэг.

Стандарт шаардлага хангасан барилга байгууламж, тоног төхөөрөмж, инженерийн шугам сүлжээтэй. Энгийн болон хагас, бүтэн люкс өрөөнүүдэд амрагчдын ая тухыг хангах бүх л зүйлсээр тохижуулсан бөгөөд телевиз, интернэт, халуун хүйтэн ус, өрөөний үйлчилгээтэй нэг ээлждээ 50 сувилуулагч, амрагч хүлээн авах хүчин чадалтай захирал 1, менежер 1, дотрын 2 эмч, уламжлалтын 2 эмч, сувилагч 3, соёлын ажилтан 1, тогооч 2, бариач 2, үйлчлэгч 3, аж ахуйн туслах 4 нийт 20 ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байна. Жилд дунджаар 1800 сувилуулагч хүлээн авдаг. ЭМЖЖ сувилал нь Хөдөлмөр халамж үйлчилгээний газартай хамтран ажилладаг бөгөөд 55-аас дээш насны эмэгтэй, 60-аас дээш насны эрэгтэй ахмад настнууд хөнгөлөлттэйгөөр амарч байна.

Сувиллын дэргэдэх хөдөө аж ахуйн фермерээс өөрийн бэлтгэсэн цэвэр сүү, цагаан идээ, махны хэрэгцээг, ногооны талбай, хүлэмжээс байгалийн цэвэр хөрсөнд ургасан хүнсний ногооны хэрэгцээгээр амрагч, сувилуулагчдыг тасралтгүй хангаж байна.

Төслийн үндсэн тоног төхөөрөмж:

- ЭМЖЖ сувиллын 2 давхар А барилга-1 ш Үүнд:

Нэг давхарт

- Хүлээлгийн өрөө
- Хүлээн авах
- Дасгалын өрөө
- Саун
- Люкс өрөө-2 ш

Хоёр давхарт

- Эмчийн өрөө
- Үзлэг эмчилгээний өрөө
- Амрагчдын өрөө- 7 ш
- Ариун цэврийн өрөө

- ЭМЖЖ сувиллын 2 давхар Б барилга-1 ш Үүнд:

Нэг давхарт

- Оффис
- Агуулах
- Ахмадуудад зориулсан өрөө-2ш
- Угаалгын өрөө

Хоёр давхарт

- Люкс өрөө-2 ш
- Физик эмчилгээний танхим
- Амрагчдын өрөө- 3 ш

- ЭМЖЖ сувиллын 1 давхар В барилга-1 ш Үүнд:
 - Нэг давхарт
 - ✚ Гал тогоо
 - ✚ Хоолны танхим
 - ✚ Хүнсний тухлаг
 - ✚ Караоке
 - ✚ Бүжгийн заал
- Зуны эмчилгээний хэсэг Үүнд:
 - ✚ Шавар эмчилгээний барилга
 - ✚ Усан эмчилгээний барилга
 - ✚ Амрагчдын шовгор сууц-2 ш
 - ✚ Амрагчдын монгол гэр сууц- 2 ш
 - ✚ Амрагчдын шавар гэр сууц- 4 ш
 - ✚ Президент хаус- 1 ш
 - ✚ Соёлын гэр
 - ✚ Тусгаарлах гэр
 - ✚ Боловсон ариун цэврийн байгууламж
 - ✚ Био ариун цэврийн байгууламж
- Сүүдрэвч
- Сагс, волейболын талбай
- Хүүхдийн тоглоомын талбай
- Хүлэмж
- Мод үржүүлэг болон ногооны талбай
- Зоорь
- Ногоон байгууламж
- Явган хүний зам
- Машины зогсоол
- Зам талбайн гэрэлтүүлэг

Төсөл хэрэгжих орчны дэд бүтэц:

- *Усан хангамж:* Унд ахуйн хэрэглээний усыг өөрийн эзэмшлийн гүний худагас хангадаг;
- *Бохир ус зайлуулах:* Бохироо соруулах системээр шийдсэн. 100 тонны ёнкост хуримтлуулж бохир соруулах гэрээний дагуу тогтмол хугацаанд соруулна;
- *Цахилгаан эрчим хүч, дулааны хангамж:* Төвлөрсөн цахилгааны эх үүсвэрээс хангадаг;
- *Харилцаа холбоо:* Үүрэн холбооны операторууд болох Mobicom, Skytel, Unitel, G-mobile операторуудын сүлжээгээр холбоо барих бүрэн боломжтой;



Зураг 3. “ЭМЖЖ сувилал” нь А болон Б корпус 2 давхар байгууламж, 60 хүний багтаамж бүхий ресторан



Зураг 4. Төслийн талбайн барилга байгууламжийн зураг



Зураг 5. Сувиллын амрагчийн өрөө нь энгийн болон люкс ангиллын бөгөөд шаардагдах тохижилт бүрэн хийгдсэн





Зураг 6. Сувиллын хөдөлгөөн заслын болон бялдаржуулах танхим, спорт зал, гадаа талбай нь орчин цагийн хэрэглэгчийн хүсэл шаардлагад бүрэн нийцнэ



Зураг 7. Автомашины зогсоол болон явган хүний зам гэрэлтүүлэг, сүүдрэвч

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Төв аймгийн Баянчандмань сумын байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга

Товч тодорхойлолт: Төв аймгийн Баянчандмань сум нь 1936 онд байгуулагдсан, хуучнаар Түшээт хан аймгийн Илдэн гүний хошуу. Төв аймгийн баруун хойд хэсэгт, Улаанбаатар хотоос 72 км, аймгийн төвөөс 110 км зайд байрладаг. Улаанбаатар хот болон Төв аймгийн Батсүмбэр, Борнуур, Баянцогт сумтай хиллэдэг.

Уур амьсгал: Уур амьсгалын мужлалын хувьд чийглэгдүү, сэрүүн нэн хүйтэн; хуурайдуу, сэрүүвтэр хүйтэн, нэн хүйтэн бүсүүдэд оршдог.

Монгол оронд агаарын жилийн дундаж температур, жилийн нийлбэр хур тунадас газарзүйн хуваарилалт нутаг дэвсгэрийн янз бүрийн хэсэгт харилцан адилгүй. Төв аймгийн нутаг дэвсгэрийн хувьд агаарын жилийн дундаж температур нутгийн баруун хэсгээр -1...+1°C байдаг бол жилийн нийлбэр хур тунадас 175...250мм, агаарын жилийн дундаж температур нутгийн зүйн хойд хэсгээр -1...-7°C жилийн нийлбэр хур тунадас 275...425 мм байна.

Ус зүйн ус зүйн сүлжээний хувьд: Төв аймгийн Баянчандмань сум нь ус зүйн хувьд Хараа голын сав газарт хамаарагддаг.

Ургамалжилт: Төв аймгийн Баянчандмань сумын нутаг болон төслийн талбай нь ойт хээрийн бүсэд багтана. Хуурайсаг өвслөг ургамал зонхилсон нутгийг хээр гэдэг. Ургамлан нөмрөгийн онцлог нь энэ нутагт өндөр уул, ойт хээр, уулын нуга, уулын хээр, нуга зэрэг байгалийн бүс бүслүүрийн ургамалжилт илэрдэг.

Ургамал-газарзүйн мужлалаар Евроазийн шилмүүст ойн их муж, Сибирийн тайгын дэд мужийн, Дагуурын уулын хээрийн дэд хошууны Монгол дагуурын уулын ойт хээрийн тойрогт хамаарна. (Өлзийхутаг, 1989).

Газрын гадаргуу: Төв аймгийн нутгийн ихэнх хэсэг далайн түвшнээс дээш 1200-1500 метр өргөгдсөн, Хэнтийн нуруу оргил нь (Асралт хайрхан 2800 м), Тосон заамар, Зоргол хайрхан зэрэг уулархаг гадаргуутай. Нутаг дэвсгэрийнх нь 16.4% нь ой мод, 36.5 % нь хээрийн бүс эзэлдэг. Газар зүйн байршлаар хангай Хэнтий уулархаг Дорнод Монголын талархаг мужид багтана. Нутгийн хойд хэсгийн уулын өргөн хөндийнүүд нь газар тариаланд тохиромжтой хүрэн бор хөрстэй. Өмнөд хэсэг нь гүвээ толгод бүхий тал хээр газар юм.

Газарзүйн байршлаар: Физик газарзүйн мужлалаар Хэнтийн нурууны баруун хэсгийн үргэлжлэлийн уулархаг мужийн тойрогт багтана.(Цэгмид, 1969). Энд Хэнтий салбар уулс намсан замхарч гадаргуу толгод бэсрэг уулсын төрхтэй болдог. Бэсрэг уулс, толгодууд уулсын хоорондох өргөн хөндийнүүдтэй ээлжлэн тааралдах боловч тэгшдүү газар талбайн хувьд төдий л их бус юм. Баянчандмань сумын газрын сангийн ангиллыг доорх хүснэгтэнд харуулав. Үүнд:

Хүснэгт 2. Баянчандмань сумын газрын сангийн ангилал

№	Газар нутаг	Хэмжээ (га)
1	Тусгай хэрэгцээний газар	1122
2	Хөдөө аж ахуйн газар	42256
3	Хот тосгон бусад суурин газар	2874

№	Газар нутаг	Хэмжээ (га)
4	Зам шугам сүлжээний газар	661
5	Ойн сангийн газар	14374
6	Усан сан бүхий газар	28

Хүн ам: Чандмань, Замт, Эрдэнэ гэсэн 3 багийн нийт 1131 өрхөд 3603 хүн амьдардаг. Хүн амын тоогоор Төв аймгийн 26 сумаас эхнээсээ 6-д, газар нутгийн хэмжээгээр 26-д ордог. Хүн амын нягтралаар хамгийн өндөр /5.49 хүн/га/ сум юм.

Эдийн засаг, аж үйлдвэр: Сумын хэмжээнд нийт 53 аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж 18.3 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж улсад 30.6 сая, аймагт 203.4 сая, орон нутагт 56.0 сая нийт 2090.0 сая төгрөгийн татвар төвлөрүүлж байна.

Газар тариалан: Сумын хэмжээнд жилд 60 га талбайд төмс, 3 га талбайд хүнсний ногоо тариалж 202,5 тн төмс, хүнсний ногоо хураан авч сумын дотоодын хэрэгцээнд нийлүүлдэг.

Зам тээвэр: Сумын газар нутаг дээгүүр ОХУ-ыг Нийслэлтэй холбосон улсын чанартай 35.6 км авто зам дайран өнгөрдөг. Багууд хоорондоо шороон замаар холбогддог.

Орон сууц хангамж: Сумын хэмжээнд инженерийн бүрэн хангамжтай 30 айлын нэг орон сууц байгаа бөгөөд бусад нь амины орон сууц, гэр сууц юм. 1951-1961 оны хооронд баригдсан 2 айлын нэг давхар сууцууд ашиглалтын шаардлага хангахаа байсан боловч айл өрхүүд амьдарч байна.

Цахилгаан хангамж: Сум нь Төвийн эрчим хүчний системд холбогдсон. Сумын төв дээр 1969 онд баригдсан 110/35/10 кВТ-ийн дэд станцтай.

Боловсрол: Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 24 бүлэгт 655 хүүхэд өдрөөр суралцаж, албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох сурталтанд 17 иргэн суралцаж байна. Бага ангийн хамран сургалт 98.6 хувь, суурь боловсролын хамран сургалт 97.3 хувьд хүрсэн. Ерөнхий боловсролын сургуульд мэргэжилтэй багшийн хангалт 100 хувьтай байгаа ба мэргэжил дээшлүүлэх хөрвөх сургалтанд нийт 33 багш хамрагдаж байна.

Эрүүл мэнд : Суманд улсын төсвийн 11 ортой 1 эмнэлэг, 2 эмийн сан үйл ажиллагаа явуулж, 2 их эмч, 12 эмнэлгийн тусгай мэргэжилтнүүд ажиллаж байна.


2.2. Төслийн талбайн өнөөгийн газрын гадарга, төлөв байдал

Төв аймгийн Баянчандмань сумын нутагт байрлах “ЭМЖЖ” ХХК-ийн “Улсын үйлчилгээтэй ЭМЖЖ сувилал”-ын газар нь газрын гэрчилгээний 000018766 дугаартай 7.32 га талбайд Улаанбаатар хотоос 51 километрт сувиллын үйлчилгээний стандарт шаардлага хангасан бүрэн тохижилттой өөрийн эзэмшлийн барилга байгууламжтай үйл ажиллагаа явуулж байна.


Төслийн үйл ажиллагаа жигд явагдаж, сувиллын барилга байгууламжийг стандартын шаардлагын дагуу бүрэн тохижуулсан байна.



Зураг 8. Төслийн талбайн фото зураг



Зураг 9. Төслийн талбайн районы д.т.д үнэмлэхүй өндөр (метр)



Зураг 10. Төслийн талбайн районы газрын гадаргын налуу (градус)

3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1.Нөлөөллийн хэлбэр үргэлжлэх хугацаа

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тогтоох зорилгоор шинжээчдийн хэсэг газар дээр нь очиж, төслийн талбай болон орчны байдалтай танилцаж, холбогдох судалгааг хийсэн болно.

Төслийн болзошгүй нөлөөллийг тогтоохдоо магадлан жагсаах аргыг ашиглаж, үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв. Энэ арга нь төсөл хэрэгжих үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал "х"-ээр тэмдэглэдэг. Ингэхдээ тухайн нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим зэргийг тодруулах, мөн уг нөлөөлөл байгаль орчин, экологийн тэнцвэрт байдал, орон нутгийн нийгэм-эдийн засагт хэрхэн нөлөөлөх (шууд, шууд бус, эргэж нөлөөлөх, буцалтгүй нөлөөлөх, давхардах эсэх) байдлыг үзүүлдэг.

Хүснэгт 3. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим ба эх үүсвэр

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөөр зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд эрэг	Бага зэрэг
1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт										
Газрын доорх урсцын өөрчлөлт			x							
Гадаргын урсцын өөрчлөлт			x							
Ургамлын бүтцийн өөрчлөлт	x				x					x
Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x					x
Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт			x							
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт			x							
2. Байгалийн нөөц ашиглалт										
Газрын гадаргын нөөц баялаг			x							
Бэлчээрийн байдал			x							
Эрдэс түүхий эдийн нөөц			x							
Эрчим хүчний нөөц			x							
3. Байгаль, орчны өөрчлөлт										
Газрын доорх усны чанар, хэмжээ			x							
Гадаргын усны чанар хэмжээ			x							
Агаарын бохирдол			x							
Хөрсний бохирдол			x							
Төслийн үйл ажиллагаанаас ялгарах бохирдуулагч бодис хүний эрүүл мэндэд нөлөөлөх			x							
Дуу чимээ, шуугианы нөлөө			x							
4. Байгалийн өнгө төрх, түүх, соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор										
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх			x							
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх			x							

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөөр зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд эрэг	Бага зэрэг
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх			x							
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх			x							
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх			x							
5. Нийгэмд үзүүлэх нөлөө										
Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх		x			x				+	
Үйлчилгээний салбарын ү/а-нд нөлөөлөх		x			x					+
Хүн амын орлого өөрчлөгдөж, нэмэгдэх		x			x				+	
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх			x							
6. Эдийн засагт үзүүлэх нөлөө										
Татварын орлого өөрчлөгдөх	x				x		x			+
Орон нутгийн орлого нэмэгдэх	x				x		x			+
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	x				x		x			+
Ажлын байр нэмэгдэх	x				x		x			+
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	x				x		x			+
7. Бусад нөлөөлөл										
Бохир ус хөрсөнд нэвчиж, хөрс ба грунтын усыг бохирдуулах			x							
Дүн	7	3	21	0	10	0	5	0	2	8

Тайлбар “х” сөрөг нөлөөлөл, (+) эерэг нөлөөлөл

Төслийн болзошгүй сөрөг болон эерэг нөлөөллийн хэлбэр, хугацаа, эрчмийн үндэслэлийг дараах байдлаар гаргасан болно. Үүнд:

Шууд нөлөөлөл:

- Төслийн барилга байгууламжийн нөлөөгөөр биет хэмжээгээр хөрс, ургамлан бүрхэвч үүсмэл хэлбэршлээр солигдож, шууд, урт хугацаанд сөрөг нөлөөлнө;
- Дэд бүтцийн хөгжилд эергээр, урт хугацаагаар нөлөөлнө;
- Орон нутгийн орлого, ажлын байр нэмэгдэх зэрэгт төслийн үйл ажиллагаа явагдах хугацаанд болон цаашид эергээр нөлөөлнө;

Шууд бус нөлөөлөл:

- Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд урт хугацаанд эерэг нөлөөлнө;

Хүчтэй нөлөөлөл:

- Болзошгүй нөлөөллийн үнэлгээ хийх явцад төслийн зүгээс хүчтэй нөлөөлөх нөлөө байхгүй байна.

4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Зорилго: Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах хэмжээг төлөвлөхөд оршино. Ингэхдээ тухайн арга хэмжээ бүрийг төсөл хэрэгжүүлэгч нь хэрэгжүүлж чадахуйц, бодитойгоор төлөвлөх нь чухал.

Гол зорилтууд:

- Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулахад зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх;
- Төслийн үйл ажиллагаанаас агаар, хөрс, усан орчин болон ажлын байрны нөхцөлд хэрхэн нөлөөлж байгаа талаар хяналт шинжилгээ явуулах арга хэмжээг төлөвлөх;

Хүснэгт 4. 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал

№	Ажлын нэр	Зардал мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	680.0
3	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	150.0
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	274.0
6	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	-
7	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	-
Нийт зардал		1104.0

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх үүднээс дараах арга хэмжээг бид хэрэгжүүлсэн.

Хүснэгт 5. Төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
1	Агаарын бохирдол үүсэх	Ил задгай хог хаягдал шатаахгүй байх	Төслийн талбайд	тогтмол	Үйл ажиллагааны зардал			2024 он	Агаарын тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль MNS 4585:2016
2	Авто тээврийн хэрэгслээс тоосжилт, хорт хий ялгарах	Шаардлагагүй тохиолдолд тээврийн хэрэгслийг унтрааж байх	Төслийн талбайд	тогтмол	Үйл ажиллагааны зардал			2024 он	
3		Төслийн талбайн орчимд олон салаа шороон зам үүсгэхгүй байх	Төслийн талбайд	тогтмол	Дотоод төлөвлөгөө			2024 он	
4		Сувиллын үйл ажиллагаанд хэрэглэгдэх тээврийн хэрэгслийг тогтмол үзлэг оношилгоонд хамруулж, засвар үйлчилгээг тухай бүр хийж байх	Төслийн техник хэрэгсэл	удаа	Үйл ажиллагааны зардал			2024 он	
5	Анхаарал болгоомжгүй байдлаас үүдэн галын аюул үүсэх	Гал унтраах багаж хэрэгслийн бэлэн байдлыг хянах, шалгах, цэнэглэх, байршуулах	Төслийн талбайд	тогтмол	Үйл ажиллагааны зардал			2024 он	Галын аюулгүй байдлын тухай хууль /2015 он/
6	Цахилгааны утаснаас гал алдахгүй байх нөхцөлийг бүрдүүлэн цахилгааны сүлжээнд үзлэг шалгалт тогтмол хийх	Төслийн талбайд	тогтмол	Үйл ажиллагааны зардал			2024 он		
Дүн							-		
Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
7	Усан орчин бохирдох, Усны нөөц хомсдох	Борооны ус хуримтлуулан ногоон байгууламжийн усалгаанд дахин ашиглах зөвлөмж	Ус хэмнэх	ширхэг	Үйл ажиллагааны зардал			2024 он	“Усны тухай хууль” Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль MNS 6561:2015 MNS 4943:2015 MNS 6734:2018
8		Ус бохирдуулсны төлбөр төлөх	Хаягдал бохир усны цооног	удаа	Үйл ажиллагааны зардал			2024 он	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
9		Ус хэмнэх технологи хэрэгжүүлэх /ариун цэврийн өрөөнд ус хэмнэдэг сантехникийн төхөөрөмжүүдийг суурилуулах/	Иж бүрэн	ширхэг	Үйл ажиллагааны зардал			2024 он	“Усны тухай хууль” “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам” БОНХАЖ-ын сайд, БХБ-ын сайдын хамтарсан тушаал-А-230/127 тоот журам “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”
10		Ус хангамжийн эх үүсвэрээс 50 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүс, 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтоож мөрдөж ажиллах	Төслийн талбай	удаа	Үйл ажиллагааны зардал			2024 он	
11	Усны чанар	Бохир ус зайлуулах цэгийн эзлэхүүний дүүргэлт 70-80 хувь хүрсэн үед суллаж, цэг болон цэгийн орчинд халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжээр халдваргүйжүүлэлтийг тогтмол хийлгэнэ.	Бохир ус зайлуулах цооног, түүнээс үүсэх бохирдлыг хязгаарлах	удаа	Үйл ажиллагааны зардал			2024 он	БОАЖ-ын сайд, ЭМ-ын сайдын хамтарсан тушаал-А/82/128 тоот журам
12									
13		Гүний худгийн усны түвшнийг тогтмол хугацаанд хэмжих	Гүний худаг	м	-	Жилд 1 удаа	Үйлд ажиллагааны зардал	2024 он	
Дүн									
Хөрс, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
14	Хөрсний бохирдол	Төслийн үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдлыг орон нутгаас зөвшөөрөгдсөн цэгт хаяж зайлуулах	Төслийн талбайд	Тогтмол	Үйл ажиллагааны зардал			2024 он	MNS 5850:2019, “Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS 3297 : 2019 “Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин
15		Төслийн талбайн нийтийн эзэмшлийн хэсгүүдэд хогийн сав байршуулах	Төслийн талбайд	ширхэг	Үйл ажиллагааны зардал			2024 он	
16		Авто машины зогсоол дээр асгарсан тос, тосолгооны	Төслийн талбайд	удаа	Үйл ажиллагааны зардал			2024 он	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
		материалыг тухай бүрд нь цэвэрлэж авах							газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх” MNS 4596:2014 Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм
17		Барилга байгууламжийн гадна талбайд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, орчныг цэвэр байлгах	Төслийн талбайд	удаа	Үйл ажиллагааны зардал		2024 он		
18		Тээврийн хэрэгслийн болон явган хүний зам, зогсоол байгуулах, тэмдэг, тэмдэглэгээ байршуулах, хаалт хамгаалалт хийх			Үйл ажиллагааны зардал		2024 он		
19		Хөрсөн орчны мониторинг судалгааг хийх	Төслийн талбайн хөрс	удаа	-	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан	2024 он		
20		Орон нутгаас сар бүр зохион байгуулдаг бүх нийтийн цэвэрлэгээнд идэвхтэй оролцон сувиллын талбайн орчимд цэвэрлэгээ зохион байгуулах	Төслийн талбайн орчим	удаа	Үйл ажиллагааны зардал		2024 он		
Дүн							-		
Биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
21	Ургамал	Сувиллын хашаан доторх сул чөлөөт талбайг тарималжуулж нөхөн сэргээх зөвлөмж	Төслийн талбай	удаа	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөнд зардал тусгагдсан		2024 он		Нөхөн сэргээлтийн аргачлал Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
22	Амьтан	Цахилгаан дамжуулах шугамын шувуунд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмж	Төслийн талбайн цахилгааны шугам	ширхэг	Үйл ажиллагааны зардал		2024 он		Амьтны тухай хууль
23		Төслийн талбайн орчимд амьдрах зэрлэг ан амьтанд хаврын улиралд хужир тавьж өгөх	Төслийн талбайн орчим	удаа	Үйл ажиллагааны зардал		2024 он		
Дүн							-		
Эрчим хүч									

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
24	Цахилгаан эрчим хүчний хэрэглээ	Цахилгаан эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмжийг сонгож хэрэглэх	Төслийн талбай	Иж бүрэн	Үйл ажиллагааны зардал			2024 он	-
25		Ариун цэврийн газар нь агааржуулагч сэнстэй байна.	Ариун цэврийн өрөө	Иж бүрэн	Үйл ажиллагааны зардал			2024 он	-
Дүн							-		
Нийт дүн							-		

6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд нэгдэж төслийн талбайд 100 ширхэг мод тарина.

Хүснэгт 6. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ногоон байгууламж бий болгох	Хайлаас	Төслийн талбай	ш	100	430,000	2024 он	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах MNS 6260 : 2020
2		Зүлэгжүүлэх	Төслийн талбай	га	50	250,000	2024 он	
3	Хөрс бэлтгэх Нүх бэлтгэх	/Хар шороо, элс, бууц зэргийг бэлтгэнэ/	Ажилчны хөлс	Ажилчин	Дотоод зардал		2024 он	
Нийт дүн						680,000		

7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны явцад түүх соёлын өвийг хамгаалах зорилгоор төсөл хэрэгжүүлэгч нь дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Соёлын өвийг хамгаалах, хадгалах Монгол улсын хууль эрхзүйн орчныг дагаж мөрдөх;
- “Улсын үйлчилгээтэй ЭМЖЖ сувилал”-ын эзэмшлийн талбайн газар дээр ямар нэг таних тэмдэггүй дурсгал илэрч болзошгүй тул төсөл хэрэгжүүлэх явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл төсөл хэрэгжүүлэгч ажлаа зогсоож энэ тухай сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх;

Төслөөс шууд өртөж нөлөөлөгдөхөөргүй цэгүүдийг хамгаалах ажиллагаа, соёлын ба үнэт өв дурсгалтай газрыг хамгаалах төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулахдаа төв, орон нутгийн удирдах байгууллага, мэргэжилтнүүд, орон нутгийн олон нийтийн байгууллага, ШУА-ын Археологийн Хүрээлэн зэрэгтэй зөвлөлдөнө. Энэ төлөвлөгөө, хөтөлбөрийг төслийн бүтээн байгуулалт эхлэхээс өмнө төлөвлөж мөрдөх;

Хүснэгт 7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Төслийн үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирж болзошгүй.	Хэрэв төслийн үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирэхэд төрийн холбогдох байгууллагуудад заавал мэдэгдэх ёстой.	Төсөл хэрэгжүүлэх нийт талбайн хэмжээнд	-	Тухайн үед нь шийдэх	Тухайн үед нь шийдэх	Үйл ажиллагааны турш	Соёлын өвийг хамгаалах тухай хууль /2014 оны 05 сарын 15-ны өдрийн шинэчилсэн найруулга/, Бусад холбогдох салбарын яамнаас гаргасан дүрэм журмууд
Нийт дүн						-		

8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдлыг ангилан ялгаж дахин ашиглах боломжтой хог хаягдлыг хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгт хүлээлгэн өгч байнга хамтран ажиллан хог хаяглын хэмжээг бага байлгахад анхааран ажиллах.

Хүснэгт 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
1	Ахуйн	Үйлчлүүлэгчдийн байрлах байр бүрд зохих өнгө үзэмж бүхий хогийн сав байрлуулах	Төслийн талбайд	ширхэг	-	150.0	2024 он	БОАЖ-ын сайдын А/433 тогтоол Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, Хог хаягдлын тухай хууль MNS 5344:2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага
2		Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, ангилан ялгасан хог хаягдлыг хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгт тушаах, хог хаягдлыг дахин ашиглах зэрэгт 3R-ийн зарчмыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх.	Төслийн талбайд	Тогтмол	Үйл ажиллагааны зардал	2024 он		
3		Төслийн талбайд хог хаягдлыг ангилан ялгаж хаях боломжтой хогийн савыг байрлуулах, хаягжуулах	Төслийн талбайд	Иж бүрэн	Үйл ажиллагааны зардал	2024 он		
4		Сувиллын нийтийн эзэмшлийн талбай, үйлчилгээний орчинд болон хариуцан хамгаалах талбайн орчинд хогийн сав байршуулах.	Төслийн талбайд	Ширхэг	Үйл ажиллагааны зардал	2024 он		
5		Ахуйн шавж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэлтийг “MNS 5161-3:2002, Ахуйн шавж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэлд. Гуравдугаар хэсэг. Үйлчилгээ стандартын дагуу мэргэжлийн газраар гүйцэтгүүлэх.	Хог хаягдлын цэгт	Улиралд 1 удаа	Үйл ажиллагааны зардал	2024 он		
6		Хог хаягдлыг тогтмол хугацаанд зайлуулах, орон нутгийн тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар хог устгалын цэгт хүргэх	Төслийн талбайд	Тогтмол	Үйл ажиллагааны зардал	2024 он		
Нийт дүн						150.0		

9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Хугацаа давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Төсөв, мян. төг	Хууль, бодлого, стандарт
Агаарын чанар						
CO ₂ , NO ₂ , SO ₂ Тоос нийт (PM10, PM2.5) Дуу шуугиан хэмжээ	- Аялал жуулчлалын баазын барилга дотор -1 цэг - Төслийн талбайн хашаан дотор-1 цэг	Жилд 1 удаа	2 цэгт	76,000төг	76.0	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн шаардлага
Хөрс						
Орчны хөрсөн дэх эмгэг төрүүлэгч бактерийн тоо	- Ариун цэврийн байгууламжийн ойролцоо-1 цэг - Хөрсний ерөнхий төлөвийг төлөөлж чадахуйц-1 цэг	Жилд 1 удаа дулааны улиралд	2 цэг	25,000төг*2 цэг*	50.0	MNS 3297:2019 Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх
Усны чанар						
Ундны усан дахь эмгэг төрүүлэгч бактерийн тоо	- Худгийн ус-1 цэг	Жилд 1 удаа	1 цэгт	45,000 төг*5 жил	45.0	MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
Ундны усны бүрэн шинжилгээ	- Худгийн ус-1 цэг	Жилд 1 удаа	1 цэгт	45,000 төг	45.0	
Ундны усан дахь хүнд металлын агууламж	- Худгийн ус-1 цэг	Жилд 1 удаа	1 цэгт	58,000 төг	58.0	
Нийт дүн					274.0	

10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан
			2024 он			
			сар	сар	сар	
	1	2	3	4	5	7
1	Төсөл хэрэгжих орон нутгийн удирдлагатай нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллах.	Тохиролцох		5 сар		ЭМЖЖ ХХК
2	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Дотоод төлөвлөлтөөр		1-р сар		ЭМЖЖ ХХК -ийн Сувиллын захирал
3	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохих хугацаанд хийж гүйцэтгэх ба биелэлтийг жил бүр дүгнэж, дүнг БОАЖЯ-нд хүргүүлж байх, тухайн жилийн БОМТ-г батлуулж байх	-			11-12-р сар	ЭМЖЖ ХХК -ийн Байгаль орчны мэргэжилтэн
Нийт дүн		-				

11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 11. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	БОМТ-н жилийн төлөвлөгөө	БОННУ-р тодорхойлсон сөрөг нөлөөллийг бууруулах, зөвлөмж, батлагдсан БОМТ-нд үндэслэн тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах	Жил бүрийн 12-р сард	Дотоод зардлаар	Байгаль орчны мэргэжилтэн	БОАЖЯ
2	Төв аймгийн БОАЖГ-г	БОМТ-н жилийн тайлан	Төлөвлөгөөний хэрэгжилт, ОХШХ-н хэрэгжилт	Жил бүр 11-р сарын 1-ний дотор	Дотоод зардлаар	Байгаль орчны мэргэжилтэн	Төв аймгийн БОАЖГ
Нийт					-		